



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А265

Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/106 дугаартай “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар байгуулагдсан “Газрын тусгай үйлчилгээ шатахуун хангалтын албаны хэрэгцээнд шаардлагатай автомашины дугуй” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Б.Мөнхбаатар (Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн) гэснийг О.Тэмүгэ (Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн) гэж өөрчилсүгэй.

2.Бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Н.Баттөр)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (О.Тэмүгэ)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА